“Уулс Заамар” ХХК-ий ашиглалтын тусгай зөвшөөрлийн MV-004691 тоот Урд дэлэн алтны шороон ордын талбайн хэмжээ нь 73.63 га бөгөөд үүнээс 2022 онд олборлолтын үйл ажиллагааны улмаас 3217.05 мян.м³ хөрс хуулж, 154.94 мян.м³ элс олборлож 10.26 га талбай эвдрэлд өртөж үүнээс 1.54 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийх төлөвлөгөөтэй ажилласан.

Техникийн нөхөн сэргээлтийг 10.65 га талбайд хийж төлөвлөгөөгөө давуулан биелүүлсэн үр дүнтэй ажиллаа.

6.1.Техникийн нөхөн сэргээлт

“Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага MNS5917:2008” стандартын шаардлагыг баримтлан дотоод овоолгын талбайд хэлбэржүүлэлт хийсэн.

Үржил шимт хөрсийг хуулах ажил.

Тус уурхайн орчмоос үржил шимт хөрсний дундаж зузааныг 0.3-0.5 м байхаар тооцож, экскаватор болон бульдозерыг хослуулан хуулж, техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайд конусан овоолго хийсэн. Уул-техникийн нөхөн сэргээлтийг хийж дууссан газар нь өөрөөр хэлбэл биологийн нөхөн сэргээлт хийх хэсэгт тухайн жилийн олборлолтын ажил зогсохоос өмнө шимт хөрсөөр хучсан.



Зураг №10. Шимт хөрс хуулах, байршуулах явц

Уурхайн ашиглагдсан орон зайд хөрсийг овоолох.

Уулын ажлын улмаас эвдрэлд өртөх газрын хэмжээг багасгах зорилгоор ухагдсан орон зайд, хоосон чулуулаг, хөрсний овоолго, тунгаагуурын нуурыг байрлуулж, газрыг аль болох оновчтой ашиглаж ажилласан.



Урд дэлэн алтны шороон ордын хувьд ашиглалтын явцад хуулсан хөрсөө ашиглагдсан орон зайд шууд овоолж ажилласан бөгөөд техникийн нөхөн сэргээлтийн зардал нь олборлолтын зардалд ордог давуу талтай. Энэ нь олборлолттой зэрэгцүүлэн шууд нөхөн сэргээлт хийх бодит боломжийг бүрдүүлсэн.



Зураг №11. Дотоод овоолго хэлбэржүүлж нөхөн дүүргэлт хийж байгаа байдал

Хөрсний овоолгыг тэгшлэх.

Хөрсний овоолго нь ашиглагдсан орон зайд хийгдэж байгаа учир зөвхөн оройн хэсгүүдийг тэгшлэх, хэлбэржүүлэх замаар техникийн нөхөн сэргээлтийг хийх бүрэн боломжтой юм. Хөрсний овоолгыг тэгшлэх зардал нь олборлолтын зардалд ордог болохоор тусд нь зардалд тооцдоггүй.



Зураг №12. Дотоод овоолгыг хэлбэржүүлэн тэгшилж буй байдал



Шимт хөрсөөр хучих.

Тэгшилсэн гадаргууг 0.3-0.6 м орчим зузаантай шимт хөрсөөр хучиж өгсөн.



Зураг №13. Нөхөн дүүргэлт хийсэн газар, шимт хөрсний конусан овоолго хийсэн байдал

6.2.Биологийн нөхөн сэргээлт

2022 онд 10.65 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийсэн бөгөөд биологийн нөхөн сэргээлтийн ажил төлөвлөөгүй болно.

“Уулс Заамар” ХХК-ий Урд дэлэн уурхай дээр “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнтэй уялдуулан 5000 ширхэг Бургас модыг тариад байна.



Зураг №14. Бургас мод тарьсан байдал



Хүснэгт 7. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Төлөвлөлтийн тоо хэмжээ	Төлөвлөлтийн нийт зардал, төгрөг	Гүйцэтгэлийн тоо хэмжээ	Гүйцэтгэлийн нийт зардал, төгрөг
1	2	3	4	5	6	7	8
1	Техникийн нөхөн сэргээлт /MV-004691/	Овоолсон хөрсийг түрж хэлбэржүүлэн тэгшилнэ. Өөрийн хүчээр хийх техникийн нөхөн сэргээлтийн ажлын дүн	мян.м ³ га	2788.06 1.54	- 369,600	- 10.65	- 2,556,000
Нийт					369,600		2,556,000



1. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Уул уурхайн үйл ажиллагааны дараа нөхөн сэргээлтийг маш сайн хийсэн ч нөлөөлөл ямар нэг хэлбэрээр үлддэг. Тэрхүү нөлөөллийг бууруулах олон арга байдгийн нэг нь дүйцүүлэн хамгаалах үйл ажиллагаа юм. Тиймээс төслийн нөхөн сэргээлтийн ажлын дараагаар үлдвэр нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах шаардлагатай.

“Уулс Заамар” ХХК-ий хувьд 2022 онд MV-004691 тоот тусгай зөвшөөрлийн дугаартай Урд дэлэн алтны шороон ордод олборлолтын үйл ажиллагаа явуулахаас гадна MV-000926 тоот тусгай зөвшөөрлийн дугаартай Заамарын Эх алтны шороон ордод олборлолт, нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа явууллаа.

Иймд тус компаний хувьд дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлсний үр дүнд тухайн газрын биологийн олон янз байдал хэвийн нөхцлөөс илүүтэйгээр сайжирсан байх нь дүйцүүлэн хамгааллын эцсийн үр дүн болно. Урд дэлэн алтны шороон ордын биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөг БОАЖЯ, НҮБХХ-ийн “Монгол орны баруун бүсэд газрын доройтол, хөгжлийн сөрөг нөлөөллийг бууруулах, дүйцүүлэн хамгааллыг нэвтрүүлэх нь” төсөл болон Дэ Нэйче Консерванси байгууллагын ажилтнуудын боловсруулсан “Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх гарын авлага”-ын дагуу хийж гүйцэтгэсэн.

Нийт талбайн хэмжээнд нөхөн сэргээлтийн ажил бүрэн дуусаагүй байгаа учир ирэх онуудад биологийн нөхөн сэргээлт хийх талбайнуудад Туул голын урсацыг сэргээх, хөрсний чийгээр баяжуулах зорилгоор мод бургасны суулгац суулгасан.

Төв аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас ирүүлсэн санал хүсэлтийн дагуу дүйцүүлэн хамгаалах хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн эвдрэлд орсон талбайд техникийн нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн. Уг газар нь хууль бусаар ашигт малтмал олборлогчид ажиллаж, нөхөн сэргээгээгүй орхисон нийт 8 га талбайд техникийн нөхөн сэргээлтийг Монгол улсын стандартын дагуу хийж гүйцэтгэлээ.

“Уулс Заамар” ХХК-ий хувьд 2022 онд нийт 8 га талбайд дүйцүүлэн хамгаалах техникийн нөхөн сэргээлт хийсэн бөгөөд үүнээс Урд дэлэн уурхайн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлангийн хүрээнд 2 га талбай нь хамрагдах юм.



Техник нөхөн сэргээлт хийсэн 2 га талбай

Хүснэгт 8. Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөний биелэлт

№	Төсөл хэрэгжих талбай	Хамгааллын арга хэмжээ	Төлөвлөлт	Биелэлт
1	MV-004691 тусгай зөвшөөрөл	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд тарих модны хэмжээ	5000 ш	5000 ш
2	MV-004691 тусгай зөвшөөрөл	Орон нутгийн тусгай хэрэгцээний газарт техникийн нөхөн сэргээлт хийх талбайн хэмжээ	1 га	2 га

2. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Манай компаний Урд дэлэнгийн MV-004691 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн 73.63 га талбайд өвөлжөө, хаваржаа зэрэг нүүлгэн шилжүүлэх объект байхгүй болно.

3. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Урд дэлэн алтны шороон ордын MV-004691 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд 2009 онд хийгдсэн хайгуулын ажлаар түүх, соёлын өв тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээнд байхгүй болох нь тогтоогдсон.



4. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Эрсдлийн үнэлгээнд химийн хорт болон аюултай бодисын хор, аюулын шинж чанар, болзошгүй эрсдлийг судлан тодорхойлох, түүнээс сэргийлэх арга хэмжээ болон хаягдлыг хоргүйжүүлэх, устгах асуудлыг хамруулан хийдэг. “Уулс Заамар” ХХК-ий Төв аймгийн Заамар сумын нутагт хэрэгжих Урд дэлэн алтны шороон орд төслийн хувьд хүний эрүүл мэнд болон байгаль орчинд шууд нөлөөлөх онцгой химийн хорт бодис болон цацраг идэвхит аюултай бодис ашигладаггүй.

5. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Үйлвэрлэлийн хэсэгт хатуу шингэн хог хаягдал (байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй) гарахгүй болно. Харин тосгоны төвд 150 орчим хүн амьдарна гэж бодвол хоногт ахуйн хэрэгцээнд 6 тн ус, усны хэрэгцээнд 3 тн ус хэрэглэж ахуйн шингэн хог хаягдал (халуун ус, гуанз, угаагуур г.м) 6 тн гаруй хаягдах бөгөөд үүнийг тусгай ухаж битүүмжилсэн газарт хаяж устгах шаардлагатай. Тосгоны хэмжээнд нэг нийтийн бие засах газартай ба үүнийг долоо хоног тутам зориулалтын уусмалаар ариутгаж байсан.

Тосгоны хэмжээнд хоногт 50 кг орчим хатуу хог хаягдал бөөгнөрдөг. Эдгээр хатуу хог хаягдлыг тусгай газарт бөөгнөрүүлэн сумын хог устгах газартай гэрээ байгуулж устгал хийлгэж ажилласан.

5.1. Хатуу хог хаягдал

Үүнд:

- Ахуйн хуурай хаягдал
- Үйлдвэрийн хуурай хаягдал
- Олборлолт ба боловсруулалтын хаягдал

Ахуйн хуурай хаягдал

Ахуйн хог хаягдал нь ерөнхийдөө хүнсний зүйлсийн үлдэгдэл, тэдгээрийн сав баглаа боодол, цаас зэрэг байна. Эдгээр хаягдлын ихэнх нь биологийн замаар задарна. Ахуйн хог хаягдлыг уурхайн тосгоноос 50 метрийн зайд байрлах хатуу хог хаягдлын цэгт цуглуулж, орон нутгийн тохижилтын албатай гэрээ байгуулан зөвшөөрөгдсөн



хогийн цэгт зөөвөрлөн хаясан.



Зураг 1. Ажилчдын тосгоноос хог хаягдлыг цуглуулан хогийн цэгт хүргэж буй байдал

Үйлдвэрийн хуурай хаягдал

Үйлдвэрийн хог хаягдалд хаягдал металл, тоног төхөөрөмжийн эд анги, эвдэрч, гэмтсэн тоног төхөөрөмж, машин механизм, дугуй, тосолгооны материалын үлдэгдэл, цаас мод, шил, керамик зүйлс, уусгагчдын сав зэрэг орно.

Хортой хий үүсгэх хаягдлыг сумын хог устгах газарт тээвэрлэнэ.

Хаягдал металл, тоног төхөөрөмжийн эд анги, эвдэрч, гэмтсэн тоног төхөөрөмж, машин механизмыг цуглуулж ангилан, дахин ашиглагдах боломжтойг нь зарж худалдана, ашиглагдахгүйг нь төмрийн хаягдалд өгсөн.



Олборлолт ба боловсруулалтын хаягдал

Уурхай болон баяжуулах хэсгээс хамгийн их хог хаягдал гарна. Олборлолт ба боловсруулалтын явцад доорх төрлийн хатуу хог хаягдал гарна. Үүнд:

- Уурхайн ажиллагаанаас гарах хатуу хог хаягдал
- Гравитацийн баяжуулалтаас гарах хатуу хаягдал

1. Уурхайн ажиллагааны үед үүссэн өнгөн хөрс болон хаягдал чулуулгийг дахин боловсруулалт хийж дууссаны дараа нөхөн сэргээлт хийхэд ашиглана.

- Хөрс хуулалтын үед - 3,6%
- Тээвэрлэлтийн үед -1,5%
- Ачиж, буулгах үед - 0,5% гэж тооцно.

2. Гравитацийн баяжуулалтаас үүссэн хаягдлыг хаягдлын санд өгөгдөнө. Энд тунасан хатуу хэсэг нь хатуу хаягдлыг үүсгэх ба маш жижиг нунтаглагдсан, хоосон чулуулгаас бүрдэнэ.

5.2. Шингэн хаягдал

- Ахуйн шингэн хаягдал
- Үйлдвэрийн шингэн хаягдал

Ахуйн шингэн хаягдал

Ордод ажиллагсдын бие засах хэсэг болон гал тогооноос ахуйн хаягдал ус гарна. Энэхүү ахуйн шингэн хаягдлыг шингэн хог хаягдлын цэгт агуулах бөгөөд ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг 7 хоногт 1 удаа тогтмол хийсэн.

Үйлдвэрийн шингэн хаягдал

Үйлдвэрийн хаягдлын сангаас гарах ус нь сөрөг нөлөөлөл бүхий бохир ус байх юм. Тус уурхайн баяжуулалтын ажиллагааний хувьд технологийн усыг эргэлтийн усан санд хуримтлуулан тунгааж, процесст эргүүлэн хэрэглэж байсан.

Технологийн хаягдлыг зайлуулах арга: *Уул уурхайн үйлдвэрийн хаягдлыг зайлуулах уламжлалт арга бол тусгайлан барьсан хаягдлын далан резервуарт шууд хийх явдал юм.*

Цөөрмийн талбайн ургамал болон шимт хөрсийг хуулан авч сүүлд нь нөхөн сэргээлтийн болон үржил шимгүй хөрсийг сэргээх зэрэг ажилд хэрэглэнэ. Эргэлтийн усан сангийн доод ёроол нь хамгаалалтын давхарга бүхий бүрхүүлтэй байх ба энэ бүрхүүл нь нягтаршуулсан байгалийн шавар (жижиг ширхэглэлтэй чулуу болон шавраар



уллаж усны нэвчилтийг зогсоох) ба полиэтиленин пленкий үеэс тогтоно.

Хаягдлын цөөрмийг байгуулахдаа үерийн усны хамгаалалт хийж, хамгаалалтын хоолойнуудыг цөөрмийн ёроолд байрлуулсан.

Гравитацийн баяжуулалтаас үүссэн угаагдсан элс хаягдлын цөөрөмд тунаж, үүссэн шингэн хэсгийг насосоор татаж, буцааж технологийн хэрэгцээнд ашигласан. Хэдийгээр тус үйлдвэр нь хаягдал бохир усаа хөрс болон усны эх үүсвэрт хаяхгүй боловч ямар нэг байдлаар алдагдахаас анхааран ажиллаж байсан.

5.3. Хийн хаягдал

- Үйлдвэрлэлийн талбайд олборлох, ачих болон буулгах үед гарах тоос
- зам барилгын ажлын үед гарах тоос
- талбай дотор тээврийн хөдөлгөөнөөр гарах тоос
- үйлдвэрлэлд ашиглагдаж байгаа машин тоног төхөөрөмжийн хөдөлгүүрээс үүсэх утаа, тортог.машин механизмаас гарах утаа, хий

- Ажилчдын ахуйн хэрэглээний галлагаанаас үүсэх утаа зэрэг болно.

Автомашин утаанаас Cu, Ni, Cd, Hg зэрэг шатахууны найрлагын үндсэн хам бүрдлүүд, тэдгээрээс гадна Рb, 2п, Мп зэрэг нэмэлт хольцын элемент, тэднийг агуулагч нэгдлүүд хүрээлэн байгаа орчны агаар, хөрс, усыг ихээр бохирдуулах нөхцөлтэй юм. Мөн машины резинэн хэсгээс Р, бусад хэсгээс Мп, Ni багагүй хэмжээгээр хүрээлэн байгаа орчинд бохирдол үүсгэн тархан хүнд металлын бохирдлын талбай үүсгэх болно. Зөвхөн Рb гэхэд л нэг машинаас хоногт 423г, жилд 152 280г/105 750г хэмжээгээр хүрээлэн байгаа орчинд цацагддаг байна.

Автомашин утааны найрлагад нийтдээ 200 гаруй төрлийн хорт бодис, химийн нэгдэл оролцдог. Зарцуулагдах түлшний жингийн 15% нь ашигтай зарцуулагдаж, үлдсэн 85% нь агаарт цацагддаг байна. 1 кг шатахуун шатахдаа: бензины хөдөлгүүр 300-310 г, дизель хөдөлгүүр 80 -100 г хорт бодис ялгаруулдаг ажээ.



Хүснэгт 9. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Нийт зардал, төгрөг	Гүйцэтгэл	Нийт зардал, төгрөг
1	2	3	4	5	
1	Ахуйн	Ахуйн шингэн хог хаягдлыг бохирын цэгт хадгалж халдваргүйжүүлэх	180,000	Ахуйн шингэн хог хаягдлыг бохирын цэгт хадгалж халдваргүйжүүлсэн	180,000
		Ажиллагсдын халуун усны газар болон бие засах газрыг ариутгаж халдваргүйжүүлэх	-	Ажиллагсдын халуун усны газар болон бие засах газрыг ариутгаж халдваргүйжүүлсэн	-
2	Үйлдвэрийн	Үйлдвэрлэлийн шингэн хог хаягдлыг тунаах нуураар дамжуулан эргүүлэн ашиглах	-	Үйлдвэрлэлийн шингэн хог хаягдлыг тунаах нуураар дамжуулан эргүүлэн ашигласан	-
		Үйлдвэрлэлийн хатуу хог хаягдлыг ялгаж устгах	-	Үйлдвэрлэлийн хатуу хог хаягдлыг ялгаж устгасан	-
3	Бусад	Дахин боловсруулагдах хог хаягдлыг Улаанбаатар хот руу тээвэрлэх	-	Дахин боловсруулагдах хог хаягдлыг Улаанбаатар хот руу тээвэрлэсэн	-
		Дахин болосруулагдахгүй хог хаягдлыг багийн хог хаягдлын цэг рүү тээвэрлэх	180,000	Заамар сумтай гэрээ байгуулан тээвэрлүүлсэн	500,000
Нийт			360,000		680,000



6. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

Урд дэлэн уурхайд 2022 онд орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөгөөгөөний дагуу дараах байдлаар шинжилгээ хийлгэсэн. Хуулбарыг хавсаргав.

1. Усны орчинд тунгаагуур нуур, шүүрлийн уснаас Хан Лаб ХХК, Инженер геодези ХХК-аар шинжлүүлсэн.
2. Хөрсний орчинд шимт хөрсний овоолго, нөхөн сэргээлтийн талбай, хөрс хуулалтын бүсээс дээж авч Хан Лаб ХХК, Инженер Геодези ХХК-иар шинжлүүлсэн.
3. Агаарын орчинд бид ажилчдын хотхон, уурхайн карьер, технологийн зам дагуу газраас Цаг уур, орчны шинжилгээний газар, Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораториар шинжлүүлсэн.

Хүснэгт 10. Орчны хяналт шинжилгээ

№	Орчны хяналт шинжилгээ	Зардал, төгрөг	Гүйцэтгэл	Зардал, төгрөг
1	Усан орчны хяналт шинжилгээ	270,000	Усан орчны хяналт шинжилгээг хийлгэсэн	1,160,060
2	Хөрсөн орчны хяналт шинжилгээ	180,000	Хөрсөн орчны хяналт шинжилгээг хийлгэсэн	134,000
3	Агаарын орчны хяналт шинжилгээ	270,000	Агаарын орчны хяналт шинжилгээг хийлгэсэн	500,000
	Нийт	720,000		1,794,060



Хүснэгт 11. Тунаах нуурын усны шинжилгээний хариу

2022.05.12							
Усны химийн задлан шинжилгээний дүн							
Анион	Мг/л	Мг/экв	%, МГ-ЭКВ/Л	Катион	Мг/л	Мг/экв	%, МГ-ЭКВ/Л
Cl	56.72	1.60	16.36	NA+K	99.82	4.34	44.43
SO ₄	120.70	2.51	25.73	NH ₄	0.20	0.01	0.11
NO ₃	9.63	0.16	1.59	Ca ²⁺	60.12	3.00	30.72
NO ₂	0.05	0.00	0.01	Mg ²⁺	29.18	2.40	24.57
CO ₃	18.00	0.30	3.07	Fe ²⁺	0.30	0.02	0.16
HCO ₃	317.30	5.20	53.24	Fe ³⁺	0.00	0.00	0.00
Дүн	522.41	9.77	100.00	Дүн	189.63	9.77	100.00
Анион, катионуудын нийлбэр					Мг/л	712.03	
HCO ₃ -ийн хагасыг хассан анион катионуудын нийлбэр					Мг/л	553.4	
Хуурай үлдэгдэл					Мг/л	606.00	
Ерөнхий хатуулаг					Мг-экв/л	5.40	
pH						8.50	
Исэлдэх чанар					Мг/л	1.60	
Усны физик шинж чанар							
Шүүгдэсний өнгө						шаравтар	
Үнэр						Үгүй	
Амт						-	
Булингар						Тунгалаг	
Тунадас						үгүй	
2022.07.22							
Усны химийн задлан шинжилгээний дүн							
Анион	Мг/л	Мг/экв	%, МГ-ЭКВ/Л	Катион	Мг/л	Мг/экв	%, МГ-ЭКВ/Л
Cl	38.29	1.08	14.99	NA+K	66.46	2.89	40.16
SO ₄	80.03	1.67	23.16	NH ₄	0.10	0.01	0.08
NO ₃	3.10	0.05	0.69	Ca ²⁺	44.09	2.20	30.58
NO ₂	0.03	0.00	0.01	Mg ²⁺	25.54	2.10	29.19
CO ₃	12.00	0.20	2.78	Fe ²⁺	0.00	0.00	0.00



НСО ₃	256.28	4.20	58.37	Fe ³⁺	0.00	0.00	0.00
Дүн	389.73	7.20	100.00	Дүн	136.19	7.20	100.00
Анион, катионуудын нийлбэр					Мг/л	525.91	
НСО ₃ -ийн хагасыг хассан анион катионуудын нийлбэр					Мг/л	397.8	
Хуурай үлдэгдэл					Мг/л	434.00	
Ерөнхий хатуулаг					Мг-экв/л	4.30	
рН						8.38	
Исэлдэх чанар					Мг/л	0.80	
Усны физик шинж чанар							
Шүүгдэсний өнгө						шаравтар	
Үнэр						Үгүй	
Амт						-	
Булингар						Тунгалаг	
Тунадас						үгүй	
2022.09.29							
Усны химийн задлан шинжилгээний дүн							
Анион	Мг/л	Мг/экв	%, МГ-ЭКВ/Л	Катион	Мг/л	Мг/экв	%, МГ-ЭКВ/Л
Cl	68.02	1.92		K	2.37	0.06	
SO ₄ ²⁻	126.3	5.62		NH ₄	0.10	0.00	
NO ₂	0.08	0.00		Ca ²⁺	45.07	2.25	
NO ₃	0.22	0.00		Mg ²⁺	23.33	1.92	
CO ₃ ²⁻	1.50	0.00		Na ⁺	75.5	3.28	
НСО ₃	196.0	3.21					
Дүн	390.7	7.77	0.00	Дүн	146.3	7.51	0.00
Анион, катионуудын нийлбэр					Мг/л	536.9	
H ₂ SiO ₃					Мг/л	15.47	
Хуурай үлдэгдэл					Мг/л	460.0	
Ерөнхий хатуулаг					Мг-экв/л	4.17	
рН						8.02	
Исэлдүүлэх чадвар					Мг/л	4.96	
Усны физик шинж чанар							
Шүүгдэсний өнгө						Өнгөгүй	



Үнэр		Үгүй
Амт		-
Булингар		Тунгалаг
Тунадас		үгүй

Дээрх шинжилгээний дүнгээс харахад химийн бүрэлдэхүүнээрээ гидрокорбанатын ангийн, натрийн бүлгийн, 2-р төрлийн, чанарын хувьд цэнгэгдүү буюу дунд зэргийн эрдэсжилтэй, зөөлөвтөр ус гэж гарсан. Шинжилгээ хийсэн арга стандарт MNS 1097:1970, MNS6271:2011, MNS ISO 10523:2001, MNS ISO 6059:2005, MNS 0900:2018

Хүснэгт 12. Шүүрлийн усны шинжилгээний харуу

2022.05.11							
Усны химийн задлан шинжилгээний дүн							
Анион	Мг/л	Мг/экв	%, мг-экв/л	Катион	Мг/л	Мг/экв	%, мг-экв/л
Cl	46.09	1.3	19.88	NA+K	64.45	2.80	42.92
SO ₄	71.35	1.49	22.75	NH ₄	0.20	0.01	0.17
NO ₃	2.75	0.04	0.68	Ca ²⁺	36.07	1.80	27.57
NO ₂	0.05	0.02	0.01	Mg ²⁺	23.10	1.90	29.10
CO ₃	18.00	0.30	4.59	Fe ²⁺	0.30	0.02	0.25
HCO ₃	207.47	3.40	52.07	Fe ³⁺	0.00	0.00	0.00
Дүн	345.71	6.53	100.00	Дүн	124.12	6.53	100.00
Анион, катионуудын нийлбэр					Мг/л	469.83	
HCO ₃ -ийн хагасыг хассан анион катионуудын нийлбэр					Мг/л	366.1	
Хуурай үлдэгдэл					Мг/л	414.00	
Ерөнхий хатуулаг					Мг-экв/л	3.7	
pH						8.66	
Исэлдэх чанар					Мг/л	2.72	
Усны физик шинж чанар							
Шүүгдэсний өнгө						шаравтар	
Үнэр						Үгүй	
Амт						-	
Булингар						Тунгалаг	
Тунадас						үгүй	
2022.07.26							
Усны химийн задлан шинжилгээний дүн							
Анион	Мг/л	Мг/экв	%, мг-экв/л	Катион	Мг/л	Мг/экв	%, мг-экв/л
Cl	48.21	1.36	25.79	NA+K	26.55	1.15	21.92
SO ₄	40.01	0.83	15.82	NH ₄	0.20	0.01	0.21
NO ₃	4.47	0.07	1.37	Ca ²⁺	40.08	2.00	37.98
NO ₂	0.10	0.00	0.04	Mg ²⁺	25.54	2.10	39.88



CO ₃	12.00	0.20	3.80	Fe ²⁺	0.00	0.00	0.00
HCO ₃	170.86	2.80	53.18	Fe ³⁺	0.00	0.00	0.00
Дүн	275.65	5.27	100.00	Дүн	92.36	5.27	100.00
Анион, катионуудын нийлбэр					Мг/л		368.01
HCO ₃ -ийн хагасыг хассан анион катионуудын нийлбэр					Мг/л		282.6
Хуурай үлдэгдэл					Мг/л		398.00
Ерөнхий хатуулаг					Мг-экв/л		4.10
рН							8.42
Исэлдэх чанар					Мг/л		1.76
Усны физик шинж чанар							
Шүүгдэсний өнгө							өнгөгүй
Үнэр							Үгүй
Амт							-
Булингар							Тунгалаг
Тунадас							үгүй

Дээрх шинжилгээний дүнгээс харахад химийн бүрэлдэхүүнээрээ гидрокорбанатын ангийн, магнийн бүлгийн, 2-р төрлийн, чанарын хувьд цэнгэг буюу дунд зэргийн эрдэсжилттэй, зөөлөвтөр ус гэж гарсан.

Хүснэгт 13. Хөрсний шинжилгээний хариу

2022.05.12										
Дээжний нэр	Гүн, см	рН	Давс %	ЦДЧ, dsm	Ялзмаг, %	СаСО ₂ , %	Шингээгдсэн сууриуд мг-экв/100гр		Шим тэжээлийн элементүүд мг/100гр	
							Са	Mg	P ₂ O ₅	K ₂ O
Шимт хөрс	-	8.56	0.10	0.201	2.19	0.48	10.2	8.3	2.8	24
Дотоод овоолго	-	9.26	0.04	0.099	0.28	0.64	7.0	4.0	1.3	10
Хөрсний механик бүрэлдэхүүн										
		Механик ширхэгүүд %, ширхэгийн хэмжээ, мм								
		1.0-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01		
Дотоод овоолго	-	66.6	16.4	4.0	1.5	6.4	5.1	13.0		
Шимт хөрс	-	23.6	27.3	24.9	13.0	10.3	1.1	24.3		
2022.07.26										
Дээжний нэр	Гүн, см	рН	Давс %	ЦДЧ, dsm	Ялзмаг, %	СаСО ₂ , %	Шингээгдсэн сууриуд мг-экв/100гр		Шим тэжээлийн элементүүд мг/100гр	
							Са	Mg	P ₂ O ₅	K ₂ O
Шимт хөрс	-	9.14	0.14	0.305	0.62	2.08	7.5	5.3	1.5	5



Дотоод овоолго	-	9.75	0.15	0.331	0.09	4.16	2.4	1.3	0.4	3
Хөрсний механик бүрэлдэхүүн										
		Механик ширхэгүүд %, ширхэгийн хэмжээ, мм								
		1.0-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001		<0.01	
Дотоод овоолго	-	37.4	29.9	11.1	5.9	10.5	5.2		21.7	
Шимт хөрс	-	26.9	28.3	14.8	8.0	18.7	3.2		21.7	
2022.10.01										
Дээжний нэр	Гүн, см	рН	Давс %	ЦДЧ, dsm	Ялзмаг, %	CaCO ₂ , %	Шингээгдсэн сууриуд мг-экв/100гр		Шим тэжээлийн элементүүд мг/100гр	
							Ca	Mg	P ₂ O ₅	K ₂ O
Шимт хөрс	-	9.67	0.20	0.439	0.29	2.08	8.9	5.8	1.7	22
Дотоод овоолго	-	9.33	0.13	0.294	0.81	2.72	9.1	8.6	1.4	6
Хөрсний механик бүрэлдэхүүн										
		Механик ширхэгүүд %, ширхэгийн хэмжээ, мм								
		1.0-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001		<0.01	
Дотоод овоолго	-	12.1	22.9	19.6	5.9	24.7	14.9		45.4	
Шимт хөрс	-	12.4	40.7	27.8	0.9	8.4	9.9		19.2	

Шинжилгээ хийсэн арга стандарт MNS 3310:1991, MNS 6824:2020

Хүснэгт 14. Уурхайн агаарын шинжилгээний хариу

2022.05.05							
№	Сорьц авсан цэг	Сорьц авсан өдөр	Сорьц авсан цаг	Хүхэрлэг хий мг/м ³	Азотын давхар исэл мг/м ³	Нийт тоос /TSP/ мг/м ³	Дуу чимээ /ДБА/
1	Олборлолтын талбай /цэг 1/	05.05	10:00	0.016	0.023	0.140	50
2	Талбайн технологийн зам дагуу /цэг 1/	05.05	10:50	0.017	0.032	0.178	65
3	Ажилчдын тосгон	05.05	15:00	0.021	0.020	0.056	45
	MNS 4585:2016			0.450	0.200	0.500	60



2022.07.25							
№	Сорьц авсан цэг	Сорьц авсан өдөр	Сорьц авсан цаг	Хүхэрлэг хий мг/м ³	Азотын давхар исэл мг/м ³	Нийт тоос /TSP/ мг/м ³	Дуу чимээ /ДБА/
1	Олборлолтын талбай /цэг 1/	07.25	09:00	0.014	0.028	0.140	48
2	Талбайн технологийн зам дагуу /цэг 1/	07.25	09:50	0.017	0.036	0.158	65
3	Ажилчдын тосгон	07.25	14:00	0.018	0.021	0.076	50
MNS 4585:2016				0.450	0.200	0.500	60
2022.09.13							
№	Сорьц авсан цэг	Сорьц авсан өдөр	Сорьц авсан цаг	Хүхэрлэг хий мг/м ³	Азотын давхар исэл мг/м ³	Нийт тоос /TSP/ мг/м ³	Дуу чимээ /ДБА/
1	Олборлолтын талбай /цэг 1/	09.13	13:00	0.015	0.028	0.150	45
2	Талбайн технологийн зам дагуу /цэг 1/	09.13	13:50	0.018	0.036	0.188	71
3	Ажилчдын тосгон	09.13	16:00	0.020	0.021	0.076	48
MNS 4585:2016				0.450	0.200	0.500	60

Дуу шуугианы дундаж утга нь 57.8-56.6 ДБА байсан ба нийт 3 цэгийн 9 удаагийн хэмжилтийн дүнгээр зарим цэг дээр стандартаас өндөр байсан. Энэхүү өндөр утга гарсан цэг нь технологийн зам дагуу бөгөөд техник хэрэгсэл байнга явдагтай холбоотой.



7. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 15. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Нийт зардал, төгрөг	Хэрэгжилт	Нийт зардал, төгрөг
1	Байгаль орчны асуудлыг нэг мэргэжилтэнд хариуцуулж дотоод хяналтын ажилтан өөрөө хяналт тавин ажиллах		Байгаль орчны асуудлыг нэг мэргэжилтэнд хариуцуулж дотоод хяналтын ажилтан өөрөө хяналт тавин ажилласан	-
2	Жил бүрийн байгаль орчныг менежментийн төлөвлөгөөгөөр гүйцэтгэх ажлыг төлөвлөн боловсруулж БОАЖЯамаар батлуулан ажиллах		2022 оны байгаль орчныг менежментийн төлөвлөгөөгөөр гүйцэтгэх ажлыг төлөвлөн боловсруулж БОАЖЯамаар батлуулан ажилласан	-
3	Төслийг хэрэгжүүлэх явцад байгаль орчныг хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах, нөхөн сэргээх ажлыг чанартай хийлгэх		Төслийг хэрэгжүүлэх явцад байгаль орчныг хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах, нөхөн сэргээх ажлыг чанартай хийлгэсэн	-
4	Уулын ажлын төлөвлөгөөнд байгаль орчныг хамгаалх талаар тодорхой ажлуудыг тусган түүнийг мөрдөн ажиллах		Ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан байгаль орчныг хамгаалах талаар тодорхой ажлуудыг мөрдөн ажилласан	-
5	Нийт ажиллагсдад байгалийн баялаг ашиглах, байгаль хамгаалах асуудлаар мэргэжлийн байгууллагын хүмүүс, сум, аймгийн байгаль орчны байцаагч нараар яриа хийлгэх	100,000	Нийт ажиллагсдад байгалийн баялаг ашиглах, байгаль хамгаалах асуудлаар мэргэжлийн байгууллагын хүмүүс, сум, аймгийн байгаль орчны байцаагч нараар яриа хийлгэсэн	100,000
6	Байгаль орчин, газар ашиглалтын тайлангаа сумын иргэдийн хурлын тэргүүлэгчдийн хуралд танилцуулж тайлангаа сумын иргэдийн хурлын тэргүүлэгчдийн хуралд танилцуулж байх	100,000	Байгаль орчин, газар ашиглалтын тайлангаа сумын иргэдийн хурлын тэргүүлэгчдийн хуралд танилцуулж тайлангаа сумын иргэдийн хурлын тэргүүлэгчдийн хуралд танилцуулсан	100,000
7	Байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнг орон нутгийн иргэдийн хурал, Байгаль орчин аялал жуулчлалын яаманд танилцуулж байх	100,000	Байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнг орон нутгийн иргэдэд таниулан ажилласан	100,000
	Нийт	300,000		300,000



8. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 16. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар	Хэрэгжилт
	1	2	3	4	5	6	7
1	Хайлааст багий иргэд нийтийн тэргүүлэгчдийн хурал	Тайлан	БОМТБиелэлт	2-р улирал	БО-ны ажилтан	Сумын төвд	Танилцуулсан
2	Төв аймгийн БОАЖГазар	Тайлан	БОМТБиелэлт	4-р улирал	БО-ны ажилтан	Төв аймгийн БОАЖГазар	Тайлан хүргүүлсэн
3	БОАЖЯ-нд	Тайлан	БОМТБиелэлт	4-р улирал	БО-ны ажилтан	БОАЖЯ-нд хүргүүлнэ	Тайлан хүргүүлсэн
Нийт							



9. УРД ДЭЛЭН УУРХАЙН 2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН НИЙТ ЗАРДАЛ

*Хүснэгт 17. Урд дэлэн уурхайн 2022 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн
төлөвлөгөөний биелэлтийн нийт зардал*

№	Хийгдэх ажил	Зардал
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	192,052,628
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	2,556,000
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	4,800,000
4	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	660,000
5	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1,794,060
6	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	300,000
7	Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	-
НИЙТ ЗАРДАЛ		202,162,688